



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 66

Номгон

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийг томилж, ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах журмыг хоёрдугаар, хамтран ажиллах, мэдээлэл солилцох чиглэл, хариуцагч байгууллага, хугацааг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авч ажиллах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай харилцах асуудлыг хариуцан, батлагдсан журмыг хэрэгжүүлэн ажиллахыг ажлын хэсэг /Цэргийн штабын дарга/-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190075

D:/2018/Alban bichig/th togtool-2019

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны
өдрийн 60 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙГ
МЭДЭЭ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ОРОН ТООНЫ
БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын дарга

Гишүүд-Цагдаагийн газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Тагнуулын хэлтсийн дарга


Татварын хэлтсийн дарга

Статистикийн хэлтсийн дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

_____ оОо _____

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны
өдрийн 60 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙГ
МЭДЭЭ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ОРОН ТООНЫ
БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. “Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”-ийн холбогдох заалтыг Баянхонгор аймгийн (цаашид “аймаг” гэх) хэмжээнд хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг (цаашид “ҮАБ” гэх) хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, Үндэсний аюулгүй байдлын орон тооны бус салбар зөвлөлийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангахад энэ журмыг мөрдөнө.

1.2. Баянхонгор аймагт ҮАБ-ыг хангах бодлогыг хэрэгжүүлэх үндэс нь “Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын ҮАБ-ын үзэл баримтлал”, “ҮАБ-ын тухай хууль” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн акт болно.

1.3. Аймагт ҮАБ-ыг хангах бодлогыг хэрэгжүүлэх, ҮАБ-ыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад “ҮАБ-ын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлд заасан үндсэн зарчмыг баримтлана.

Хоёр. Журмын зорилго, хамрах хүрээ

2.1. Аймгийн нутаг дэвсгэрт “ҮАБ-ын үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэхийн тулд ҮАБ-ыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд болон бусад байгууллагууд тус тусын үйл ажиллагааны хүрээнд ҮАБ-д сөргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлийн талаар харилцан мэдээлж, үнэлгээ өгөх, сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх боломж чадавхийг дээшлүүлэхэд энэ журмын зорилго оршино.

2.2. “ҮАБ-ыг хангах тухай хууль”-д зааснаар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Засаг даргын тамгын газрын Цэргийн штаб, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Тагнуулын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх алба орон нутгийн хэмжээнд ҮАБ-ыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд мөн.

2.3. Орон нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргаа, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд нь “ҮАБ-ын тухай хууль”-ийн 7.2, 9, 10, 11, 12 дугаар зүйлд заасны дагуу өөрсдийн эрх, үүргийн хүрээнд ҮАБ-тай холбоотой асуудлаар тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай мэдээлэл, судалгааг гарган өгч хамтран ажиллана.

2.4. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд “ҮАБ-ын тухай хууль”-ийн 13, 14 дүгээр зүйлд заасны дагуу орон нутгийн хэмжээнд ҮАБ-ыг хангах үйл ажиллагаанд оролцож, туслалцаа дэмжлэг үзүүлж ажиллана.

Гурав. Аймагт үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо

3.1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ҮАБ-ыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн аймгийн хэмжээнд ҮАБ-ыг хангах бодлогыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

3.2. Аймаг, сумын Засаг дарга нар орон нутагтаа ҮАБ-ын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ҮАБ-д хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах арга хэмжээ авч, энэ асуудлаар нутаг дэвсгэртээ байгаа ҮАБ-ыг хангах чиг үүрэгтэй албадад чиглэл өгч, холбогдох байгууллагад санал, хүсэлт тавина.

3.3. Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтан ҮАБ-ыг хангах асуудлаар тогтоосон журмыг сахин биелүүлэх, төр, байгууллага, хувь хүний нууцыг чанд хамгаалах, өөрийн хууль ёсны үүрэгт хамаарах мэдээ, баримтыг холбогдох дээд байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй.

3.4. Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтан ҮАБ-ын холбогдолтой асуудлаар шийдвэр гаргах, аливаа хэлбэрээр байр сууриа илэрхийлэхдээ ҮАБ-ын үзэл баримтлал, “ҮАБ-ын тухай хууль”-ийг үндэс болгоно.

3.5. ҮАБ-ыг хангах төрийн нэгдмэл бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ҮАБ-ыг хангах бодлогод нийцүүлэн нутгийн өөрөө удирдах болон төрийн байгууллагуудын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргийг аймгийн “Аймгийн Засаг даргаар ахлуулсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсэг” хэрэгжүүлнэ.

3.6. Аймгийн Засаг даргаар ахлуулсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулна.

3.7. “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсэг нь орон тооны зөвлөлдөх байгууллага бөгөөд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, улс, үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах асуудлыг хамтран хэлэлцэж, санал нэгтгэйгээр шийдвэрлэх зарчмыг баримтлана.

Дөрөв. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсэг нь дор дурдсан эрх, үүргийг хүлээнэ

4.1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсэг нь Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ҮАБ-ыг хангах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх төлөвлөгөө болон холбогдох шийдвэрийн төсөл, саналыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээ шинжилгээ хийх,

4.2. Аймаг, орон нутгийн удирдлагуудын гадаад орны байгууллага, албан тушаалтантай хийх уулзалт, ярианы үед баримтлах чиглэл, тодорхой асуудлаар байр сууриа илэрхийлэхэд ҮАБ-ын үзэл баримтлал, төрийн гадаад бодлогод нийцүүлж зөвлөлдөн тогтоох,

4.3. Аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудал, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын гаргах шийдвэр нь ҮАБ-тай холбоотой бол тухайн асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж гаргах,

4.4. Зөвлөл нь ҮАБ-ыг хангах хууль тогтоомж болон аймагт ҮАБ-ыг хангах арга хэмжээний төлөвлөгөө, бусад шийдвэрийн дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагуудын ажилтай танилцах, мэдээллийг авч хэлэлцэх, нөхцөл байдалд үнэлгээ өгөх, ҮАБ-ын зөвлөлд танилцуулах эсэх тухай асуудлыг шийдвэрлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд чиглэл, зөвлөмж өгөх,

4.5. ҮАБ-ыг хангах асуудлаар төрийн байгууллагуудын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд чиглэл өгөх,

4.6. Аймгийн хэмжээнд ҮАБ-ын асуудлаар мэдээ, мэдээлэл гаргуулан авах, цуглуулах, дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг тодорхойлох,

4.7. Ажлын хэсэг нь аймгийн ҮАБ-ыг хангах асуудлаар цугларсан материалуудаас бүрдсэн мэдээллийн сантай байх,

Тав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн үйл ажиллагаа

5.1. Ажлын хэсэг нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. ҮАБ-тай холбоотой тодорхой асуудлаар, шаардлагатай гэж үзвэл Засаг даргын өгсөн үүргийн дагуу хугацаа харгалзахгүйгээр мэдээлэл хийнэ.

5.2. Аймгийн Засаг даргаар ахлуулсан ҮАБ-ын Зөвлөлд мэдээлэл хийх байгууллага, албан тушаалтанд тухайн аймаг, сумын нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллага, албан тушаалтан өөрийн хүлээсэн чиг үүрэгт холбогдох мэдээ, баримт бичиг, судалгааг гаргаж өгөх буюу бусад шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлнэ.

5.3. Мэдээлэл нь шалгагдсан, үнэн бодитой, фото, видео болон бусад хэлбэрээр баримтжуулагдсан, холбогдох судалгаа тооцоог хавсаргасан байх ба мэдээллийн агуулгаас шалтгаалан ил ба нууц зэрэглэлтэй байна.

5.4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нууцлалыг хангах үүрэг хүлээж, баримт бичиг, эд зүйлийн нууцлалыг чанд хадгалж хамгаалахаа баталж, нууц хадгалалтын баталгаа гаргана.

5.5. Ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн аймгийн ИТХ, Засаг дарга холбогдох шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ.

5.6. Шаардлагатай гэж үзвэл гүнзгийрүүлэн судлах, шалгах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хамтарсан ажлын хэсэг байгуулж болно.

5.7. Мэдээлэл хийгч хүндэтгэх шалтгаанаар хүрэлцэн ирэх боломжгүй үед түүнийг орлож буй албан тушаалтан мэдээлэл хийж болно.

5.8. Тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд нь хугацаат мэдээллээс гадна ҮАБ-ыг хангахтай холбоотой хойшлуулшгүй асуудал (гамшиг, гэнэтийн аюул, халдлагын талаар болон үзлэг, шалгалтын дүн, бусад байгууллага, аж ахуй нэгжид өгсөн албан шаардлага, түүний биелэлт зэрэг)-ын талаар мэдээлэл бэлтгэж аймгийн Засаг даргаар ахлуулсан ҮАБ-ын Зөвлөл, аймгийн Засаг даргад нэн даруй танилцуулна. Засаг дарга уг асуудлыг судлан үзээд холбогдох арга хэмжээг зохион байгуулна.

5.9. Зөвлөлийн хуралдааныг бэлтгэх, явуулах, хуралдаанаас гарсан шийдвэрийг хэлбэржүүлэх, ҮАБ-ын зөвлөлд хүргүүлэх, ҮАБ-тай холбоотой аймгийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх болон зохион байгуулалтын бусад ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс хариуцна.

5.10. Аймгийн прокурорын газар ҮАБ-ын үзэл баримтлалын заалтууд, ҮАБ-ыг хангах тухай хууль энэ журмын хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэйгээр, аймгийн шүүх ҮАБ-д хохирол учруулж болзошгүй гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлсэн мэдээлэл, санал өгөх үүрэгтэйгээр тус тус оролцоно.

5.11. Аймгийн Тагнуулын хэлтэс нь ҮАБ-ын бүрэлдэхүүн хэсэгт хамаарах сэдвүүдээр мэдээллийн төрөлжсөн сан байгуулж, тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд болон бусад байгууллагуудаас Засаг даргад ирүүлсэн мэдээллийг төрөлжсөн сангуудад хадгалж, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах асуудлыг хариуцаж, ҮАБ-ын үзэл баримтлалын 4.2.6-д заасны дагуу Засаг даргаас ҮАБ-ын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлнэ.

5.12. Мэдээллийн сангийн мэдээлэл нь төрийн болон байгууллагын нууцад хамаарна.

5.13. Тусгайлсан чиг үүрэгтэй болон бусад байгууллагууд ҮАБ-ын мэдээллийн санд байгаа мэдээллийг ашиглах, лавлагаа авах шаардлага гарсан үед тагнуулын хэлтэст хүсэлтээ ирүүлж хэрэгцээтэй мэдээллийг авна.

Тухайн байгууллагын чиг үүрэгт шууд хамааралгүй, албаны нууцад хамаарах асуудлаар мэдээлэл, лавлагаа авахыг хориглоно.

5.14. Тусгайлсан чиг үүрэгтэй болон бусад байгууллагууд онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу ажиллаж шаардлагатай бол түүнд тодотгол хийж бэлэн байдлын түвшинг өндөржүүлэн ажиллана.

5.15. Тусгайлсан чиг үүрэгтэй болон бусад байгууллагуудын удирдах албан тушаалтан гадаад улсад албан болон хувийн хэргээр зорчихдоо буюу тухайн орон нутагтаа гадаадын ижил төстэй байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулахдаа орон нутаг дахь Тагнуулын хэлтэс болон ажлын хэсэгт мэдэгдэж байна.

5.16. Тусгайлсан чиг үүрэгтэй болон бусад байгууллагууд нь ҮАБ-ын үзэл баримтлал, бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг ард иргэдэд сурталчлах, олон нийтэд ойлголт өгөх ажлыг орон нутгийн нэгдсэн цахим хуудас ажиллуулах, хэвлэл мэдээлэл, иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдгээрийн идэвх оролцоог урамшуулах замаар хэрэгжүүлнэ.

5.17. Аймгийн Засаг даргаар ахлуулсан ҮАБ-ийн Зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах үйл ажиллагааг хариуцсан ажилтанг томилж, түүний гүйцэтгэх үүргийг ажил үүргийн хуваарьт нарийвчлан тусгана.


Зургаа. Бусад зүйл

6.1. “ҮАБ-ын тухай хууль”-ийг зөрчигчид тус хуулийн 20.1-д заасны дагуу Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. ҮАБ-ыг хангахтай холбогдон гарах зардлыг “ҮАБ-ын тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу улсын болон орон нутгийн төсөв, төсвийн гадуурх хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.

_____оОо_____

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 26-ны
өдрийн 60 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



ХАМТРАН АЖИЛЛАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ
ЧИГЛЭЛ, ХАРИУЦАГЧ БАЙГУУЛЛАГА, ХУГАЦАА

№	Мэдээллийн агуулга	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хэнд мэдээллэх
1	2	3	4	5
1	Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн судалгаа /танилцуулах мэдээ/	6 дугаар сарын 10-ны дотор	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс
2	Аймгийн хүн ам, байгаль орчинд аюул, эрсдэл учруулж болохуйц нөхцөл байдал, үйл явдлын тухай мэдээ /шуурхай мэдээ/	Тухай бүр	Ус, цаг уур орчны шинжилгээний газар	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Цэргийн штаб
3	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээ тайлан /танилцуулах тойм мэдээ/	12 дугаар сарын 10-ны дотор	Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс
4	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт, газрын нэгдмэл сан, газрын төлөв байдал (зураглал, зурган мэдээний хамт)	12 дугаар сарын 10-ны дотор	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс
5	Ус хангамжийн эх үүсвэр, нөөц, чанар, усны байгууламж, ашиглалт, хамгаалалт (зураглал, зурган мэдээний хамт)	12 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс
6	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийн тухай (зураглал, зурган мэдээний хамт)	12 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс
7	Агаарын чанарын төлөв байдал, бохирдлыг бууруулах арга хэмжээ тухай мэдээ /танилцуулах мэдээ, жил бүр ирүүлэх/	12 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар Ус, цаг уур орчны шинжилгээний газар	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс

1	2	3	4	5
8	Хатуу, аюултай хог хаягдал, менежмент түүний тухай /танилцуулах мэдээ/	12 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс
9	Гадаад улсын элчин сайд болон бусад төлөөлөгчидтэй уулзсан уулзалтын ярианы тэмдэглэл, байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичиг /Ярианы тэмдэглэл/	Тухай бүр	Аялал жуулчлалын алба	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс
10	Цаг үеийн нөхцөл байдлын тухай шуурхай мэдээ	Тухай бүр	ҮАБ-ыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Цэргийн штаб
11	ҮАБ-ыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажлын тайлан	6 дугаар сарын 10-ны дотор	ҮАБ-ыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль эрх зүйн хэлтэс